


Хаврын улиралд цаг агаар тогтворгүй байдагтай холбоотой агаарын температурын хэлбэлзэл ихэсдэг. Манай орны 5 дугаар сарын агаарын дундаж температур (1991-2020 оны дунджаар) Алтай, Хангай, Хөвсгөл, Хэнтийн уулархаг нутаг болон томоохон гол, нууруудын сав газраар 6°C (32°F) –аас хүйтэн, говь-цөлийн бүс нутгаар $+12.1^{\circ}\text{C}$ (42.8°F) –аас $+21^{\circ}\text{C}$ (53.6°F), бусад нутгаар 6.1°C –аас $+12^{\circ}\text{C}$ (32°F –аас 41°F) хүйтэн байдаг байна.


Монгол орны хэмжээнд 5 дугаар сард хур тунадас бага унадаг ба ойролцоогоор жилийн нийлбэр хур тунадасны 7.5 хувьтай тэнцдэг. Тус сард Архангай, Булган, Сэлэнгэ, Дархан-Уул болон Хөвсгөл, Төв, Хэнтий, Дорнодын хойд хэсгээр 20-30 мм, Увс, Ховдын зарим хэсэг болон нутгийн өмнөд хэсгээр 2-10 мм бусад нутгаар 10.1-19 мм тунадас ордог байна.



Зураг 1. 1991-2020 оны 5 дугаар сарын агаарын дундаж температур, нийлбэр нийлбэр хур тунадасны орон зайн тархалт


2025 оны 5 дугаар сарын агаарын дундаж температур өмнөх жилээс -2.1°C -аар хүйтэн, ОЖД-аас 0.4°C -аар дулаан байсан бөгөөд 1940 оноос хойш тохиолдож байгаа 22 дахь дулаан сар болж өнгөрлөө. Сарын агаарын дундаж температурын ОЖД-аас хазайх хазайлтын орон зайн тархалтыг авч үзэхэд (Зураг 2) нутгийн 21.7% нь дунджаас 1.0 -ээс 3.0°C -аар дулаан, 78.3% нь дунджийн орчим байжээ.

Тус сард Монгол орны хэмжээнд дунджаар 20.2 мм хур тунадас орсон нь өмнөх жилээс 12.2%-иар, ОЖД-аас 28.2%-иар тус тус ахиу бөгөөд 1940 оноос хойш тохиолдож байгаа 12 дахь их тунадастай сар болж өнгөрлөө. Сарын нийлбэр хур тунадасны ОЖД-аас хазайх хазайлтын орон зайн тархалтыг авч үзвэл (Зураг 2) нийт нутгийн 53.5% нь дунджаас ахиу, 38.8% нь бага, 7.8% -д дунджийн орчим хур тунадас унасан байна.




Зураг 2. 2025 оны 5 дугаар сарын агаарын дундаж температур, нийлбэр хур тунадасны ОЖД-аас хазайх хазайлтын оронзайн тархалт

Монгол орноор болон 4 бүсээр хуваан дунджилсан 5 дугаар сарын хоногийн агаарын дундаж температурын явцыг авч үзэхэд (Зураг 3) 1 дүгээр 10 хоногийн ихэнх хугацаа, 2 дугаар 10 хоногийн дунд үеэс 3 дугаар 10 хоногийн эхэн хүртэл, мөн 3 дугаар 10 хоногийн сүүлээр ОЖД-аас -0.2°C -аас -6.4°C -аар хүйтэн байсан байна. Харин бусад хугацаанд ОЖД-аас 0.3°C -аас 11.5°C -аар дулаан байв. Хур тунадасны хувьд ихэнх нутгаар харьцангуй ахиу хур тунадас орсон. Ялангуяа 2 дугаар 10 хоногт нийт нутгаар ахиу тунадастай байлаа.



Зураг3. Хоногийн дундаж агаарын температур, нийлбэр хур тунадасны ОЖД-аас хазайх хазайлт

Энэ сард агаарын температурын үнэмлэхүй их утга Баянхонгор Эхийнгол 35.4°C , үнэмлэхүй бага утга Хөвсгөл аймгийн Чандагат суманд -7.1°C хүрч ажиглагдсан. Хөрсний температурын үнэмлэхүй их утга Булган аймгийн Булган суманд 65°C , үнэмлэхүй бага утга Төв аймгийн Мөнгөнморьт суманд -14°C хүрч хүйтэрсэн байна. Хоногт хамгийн ихдээ Хөвсгөл аймгийн Шинэ-Идэр суманд 04-ны өдөр 60.7 мм тунадас орсон. Харин даралтын үнэмлэхүй их утга Сэлэнгийн Сүхбаатарт 953.0гПа, бага утга Баянхонгорын Баянбулагт 763.0гПа хүрч тус тус ажиглагдсан. Салхины хамгийн их хурд Өмнөговь аймгийн Цогт-Овоо суманд 35 м/с хүрсэн байна.



Зураг 4. Тус сард ажиглагдсан экстремаль утгууд